

Голлох элемент, үзэгдэл

	Цаг уурын элемент	Хэмжигдэхүүний нэр	Хэмжлийн нэгж	Боловсруулалт	Тодорхойлолт
			Нэр/ тэмдэглээ		
1	Агаарын температур	тухайн хугацааны, хамгийн их, бага утга	цельсийн градус (°C)	Хугацаа, хоног, 10 хоног, сар, жил	Агаарын температур гэж дулааны төлөв байдлыг илэрхийлэх хэмжигдэхүүн юм.
2	Хөрсний гадаргын температур	тухайн хугацааны, хамгийн их, бага утга	цельсийн градус (°C)	Хугацаа, хоног, 10 хоног, сар	Нарны цацраг агаар мандлыг туулан газрын гадаргад тусч, туяаралын хэлбэрээс дулааны хэлбэрт шилжин халаадаг. Хөрсний гадаргын температурыг хугацаат максимум, минимум термометрээр, 5-10 см гүнийхийг Савиновын ба хатгуур термометрээр, 20, 40, 60, 80, 120, 160, 240, 320 см-ын гүний температурыг татуургат термометрээр тус тус хэмжинэ.
	хөрсний гүний	тухайн хугацааны		Хугацаа, хоног, 10 хоног, сар	
3	Агаарын даралт	тухайн хугацааны	гектоПаскаль (гПа)	Хугацаа, хоног, 10 хоног, сар	Агаар нь атом молекулаас тогтсон нэгэн төрлийн хийн бие учраас тодорхой хэмжээний жинтэй байна. Агаарын энэ жинг агаарын даралт гэнэ.
4	Даралтын хандлага	даралтын өөрчлөлт	гектоПаскаль (гПа/3ц)		Агаарын даралтын сүүлчийн хэмжлийн үр дүнгээс өмнөхийг нь хасаж даралтын ялгаварыг тодорхойлно.

5	Агаарын чийгшил	усны уурын даралт	гектоПаскаль (гПа)	Хугацаа, хоног, 10 хоног, сар	Агаарт орших усны уурын /хийн парциал/ даралт. Усны уурын парциаль даралтын нэгж нь /гПа/ юм. Усны уурын даралт нь тухайн температур тодорхой хязгаарын утгаас хэтрэхгүй.
		харьцангуй чийгшил	Хувь (%)	Хугацаа, хоног, 10 хоног, сар	Агаар дахь усны уурын даралтыг тухайн температурт байж болох усны уурын хамгийн их даралтад харьцуулж хувиар илэрхийлснийг харьцангуй чийгшил гэнэ.
		шүүдэр унах температур	цельсийн градус (°C)	Хугацаа, хоног, 10 хоног, сар	Агаарын даралт, хувийн чийгшил тогтмол байхад агаар дахь усны уур зөвхөн температурын бууралтаас болж ханасан төлөв байдалд орох үеийн температурыг шүүдэр унах температур гэнэ.
6	Салхи	дундаж, өрөвхий болон хамгийн их хурд	секунд дэх метр (м/с)	Хугацаа, хоног, 10 хоног, сар	Агаарын даралтын зөрөөнөөс үүссэн хэвтээ чиглэл дэх агаарын урсгалыг салхи гэнэ.
		чиглэл	нумын өнцөг, зовхис/ градус, $\Theta$ , X	Хугацаа, хоног, 10 хоног, сар	
7	Хур тунадас	хэвтээ гадарга дээр үүссэн усан бүрхүүлийн зузаан	миллиметр (мм)	Хугацаа, хоног, 10 хоног, сар	Хур тунадасны хэмжээ гэдэг нь бороо, цас, шиврээ, их хэмжээний шүүдэр, хяруу, хялмаа, манан, мөндөр, аадар туйдаадас зэргээс газрын гадарга дээр үрсалгүй, ууршилгүй, хөрсөнд нэвчилгүй тогтож болох усан давхаргын зузааныг миллиметрээр илэрхийлснийг хэлнэ.
8	Агаарын үзэгдэл	эхэлсэн, зогссон, үргэлжилсэн хугацаа	цаг, минут (цаг, мин)	Хугацаа, хоног, 10 хоног, сар	Цаг агаарын үзэгдэл гэдэгт “Агаар мандалд болж буй физик үзэгдэл, түүний үр дагавар, цаг уурын элемент утгын хүлэлцэх босгын давах, тэдээрийн дан буюу хам нөлөөлөл”-ийг ойлгоно. Цаг уурын өртөө, харуулуудаас харагдах орчинд болэ байгаа агаарын үзэгдлүүд, ажиглалтын завсрын хугацааны цаг агаарын байдлыг нүдэн баримжаагаар хоногийн

					туршид тасралтгүй ажиглана. Цаг агаарын үзэгдлийг физик шинж байдал, мөн чанарыг харгалзан хур тунадас, манан, будан, униар, салхи шуурга, гэрлийн үзэгдэл, бусад үзэгдлүүдэд ангилдаг.
9	Үүлшил	бүрхэц /10 баллын системээр/	балл (балл)	Хугацаа, хоног, 10 хоног, сар	Үүл гэдэг нь агаар мандалд болж буй усан дусал ба мөсөн талстын үзэгдэх хуримтлал юм. Агаар мандалд чийгийн агууламж ихсэж агаарын температур буурах явцад үүл үүснэ. Цаг уурын өртөө, харуулуудын үүлний ажиглалтаар түүний бүрхэцийн зэрэг тоо хэмжээ, хэлбэр, газрын гадаргаас дээш орших өндрийг тодорхойлдог.
10	Алсын бараа	цаг уурын алсын барааны харагдалт	метр, километр (м/км)	Хугацаа, хоног, 10 хоног, сар	Алсын бараа гэж харагдах хамгийн хол зайг хэлдэг. Цаг уурын алсын бараа /SM/ гэж хар биет агаарын будан болон манангийн дэвсгэр дээр хүний нүдний ялгах чадварын босго 0.05 хувь хүрч замхрах хамгийн хол зай юм.